



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 05 сарын 22 өдөр

Дугаар 250

Улаанбаатар хот

Дуудлага худалдааг дахин зохион байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 4, 39 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 44 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Иргэний хуулийн 177 дугаар зүйл, Засгийн газрын 2024 оны 152 дугаар тогтоол, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, Баянзүрх дүүргийн 23 дугаар хорооны нутаг дэвсгэрт байршилтай 8190.0 м² газар эзэмших эрх бүхий агуулах, аж ахуйн зориулалттай барилга, байгууламжийн нээлттэй дуудлага худалдааг 2025 оны 2 дугаар сарын 4, 2025 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр зохион байгуулсан дуудлага худалдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, Баянзүрх дүүргийн 23 дугаар хорооны нутаг дэвсгэрт байршилтай хавсралтад заасан агуулах, аж ахуйн зориулалттай барилга, байгууламжийг дахин нээлттэй дуудлагын худалдаагаар худалдсугай.

2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, Баянзүрх дүүргийн 23 дугаар хорооны нутаг дэвсгэрт байршилтай 8190.0 м² газар эзэмших эрх бүхий агуулах, аж ахуйн зориулалттай барилга, байгууламжийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах доод үнийг 20 хувиар буулгаж, хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоосугай.

3. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, Баянзүрх дүүргийн 23 дугаар хорооны нутаг дэвсгэрт байршилтай хавсралтад заасан агуулах, аж ахуйн зориулалттай барилга, байгууламжийн дуудлагын худалдааны дэнчингийн хэмжээг худалдах доод үнийн 20 хувиар, үнэ хаялцах доод хязгаарыг 5,000,000.00 (таван сая) төгрөгөөр дээд хязгаарыг дэнчингийн хэмжээгээр тус тус тогтоосугай.

4. Дуудлагын худалдааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

5. Дуудлагын худалдааны ялагчтай байгуулах "Худалдах, худалдан авах гэрээ"-нд гарын үсэг зурахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэд зөвшөөрсүгэй.

6. Шинэ өмчлөгчид шилжих хүртэл хугацааны хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хариуцан ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга З.Тулга, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг (Ц.Баяр-Эрдэнэ)-т тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

132000867
11-r_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн
№ 80 дугаар тогтоолын хавсралт

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХҮЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ДАХИН
ХУДАЛДАХ ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ

(Баянзүрх дүүргийн 23 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах
агуулах, аж ахуйн зориулалттай барилга, байгууламж, газар эзэмших эрх)

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Хэмжээ	Балансын үнэ (төгрөгөөр)	2024 оны 822 дугаар тогтоолоор тогтоосон үнэ (төгрөгөөр)	Шинэчлэн тогтоосон доод үнэ (төгрөгөөр)
1	Оффисын барилга	2014	м.кв	200.0	111,179,390.00	216,266,000.00	173,012,800.00
2	Агуулах №1	2019	м.кв	1296.0	287,077,517.00	287,078,000.00	229,662,400.00
3	Агуулах №2	2019	м.кв	1296.0	285,620,271.00	285,620,000.00	228,496,000.00
4	Граж /4 машины/	2019	м.кв	136.0	59,371,544.00	89,611,000.00	71,688,800.00
5	Бетон хашаа	2019	м.кв	120.0	2,646,483.84	6,257,000.00	5,005,600.00
6	Блокон хашаа	2019	м.кв	36.26	2,078,778.24	3,025,000.00	2,420,000.00
7	Модон хашаа	2014	м.кв	304.98	4,138,454.00	5,807,000.00	4,645,600.00
8	Бетон талбай	2019	м.кв	97.0	880,595.00	3,847,000.00	3,077,600.00
9	Төмөр хаалга /2 ширхэг/	2014	м.кв	2	1,344,606.00	1,345,000.00	1,076,000.00
Барилга байгууламжийн дүн							719,084,800.00
10	Эзэмшил газрын эрх /Э-2204900133/	2015	м.кв	8190	84,357,000.00	818,672,000.00	654,937,600.00
НИЙТ ДҮН							1,374,022,400.00 (нэг тэрбум гурван зуун далан дөрвөн сая хорин хоёр мянга дөрвөн зуу)